



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 00


Мандалговь

Г  
Д.Эрдэнэцэцэгийг Мал эмнэлгийн газрын  
Сайнцагаан сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар  
зүйчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Мал эмнэлгийн газрын Сайнцагаан сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Даваадоржийн Эрдэнэцэцэг 35.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Д.Эрдэнэцэцэгийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албананд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын  
10-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт

УЧ-0115  
10

**Мал эмнэлгийн газрын Сайнцагаан сумын Мал эмнэлгийн  
тасгийн тархвар зүйчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Д.Эрдэнэцэцэг тухай дүгнэлт**

1. Д.Эрдэнэцэцэг нь 1990 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 32 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2009-2014 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг малын эмч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Д.Эрдэнэцэцэгийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мал эмнэлгийн газрын Сайнцагаан сумын Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ**